



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/96

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн 2.4.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг тараах, ширээ засахад шаардагдах 939 500 (есөн зуун гучин есөн мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2.Уг зардлыг Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.БАТЦООЖ

